




БАГА БОЛОВСРОЛЫН МОНГОЛ ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ЭХЭД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ (Бага ангийн монгол хэлний сурах бичгийн жишээн дээр)

М.Энхжаргал^а

^аМУБИС-Багшийн сургууль, ахлах багш, доктор

Холбоо барих зохиогч: enkhjargal.m@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2024.08.25

Хянагдсан: 2024.09.20

Зөвшөөрсөн: 2024.10.25

Хураангуй

Суралцагчдын сурлагын амжилтад нөлөөлөх, эх хэлний суурь чадамжийг хөгжүүлэх, үгийн баялгийг нэмэгдүүлэх, бүтээлч сэтгэлгээтэй монгол хүүхдийг төлөвшүүлэх суурь чадвар бол унших, уншсанаа ойлгох, бичих чадвар гэдэгтэй боловсрол судлаачид санал нэгддэг. Унших чадвар нь судалж буй хичээлүүдийн агуулгыг ойлгоход төдийгүй мэдээлийн олон эхсурвалжаас өөрт хэрэгтэйг сонгох, олон янзын байр сууринаас хандах, шүүн тунгаах улмаарбие даан өргөн хүрээнд уншиж чаддаг хүн тасралтгүй суралцах чадвартай байдгийг олон судлаачид тэмдэглэсэн байдаг.

Эх хэлний хичээл нь тухайн хэлний “эх”-д тулгуурладаг бөгөөд эхийг унших, уншсанаа ярир-сонсох, ойлгосноо бичих гэсэн хэлний үндсэн чадварыг олгох зорилготой байдаг. Уг судалгаандаа бага боловсролын монгол хэлний сургалтад хэрэглэгдэж байгаа сурах бичгүүдэд туссан эхийн агуулга, төрөл зүйлд шинжилгээ хийсэн судалгааг хүргэж байна.

Түлхүүр үг

Сурах бичиг, уран зохиолын эх, хэрэглээний эх, эхийн агуулга, эхийн төрөл зүйл

Удиртгал

Суралцагчдын сурлагын амжилтад нөлөөлөх, үгийн баялгийг нэмэгдүүлэх, бүтээлч сэтгэлгээтэй монгол хүүхдийг төлөвшүүлэхийн суурь чадвар бол унших, уншсанаа боловсруулах, бичгээр илэрхийлэх чадвар гэдэгтэй боловсрол судлаачид санал нэгддэг.

Унших чадвар нь судалж буй хичээлүүдийн агуулгыг ойлгох, мэдээлийн олон эх сурвалжаас өөрт хэрэгтэйг сонгох, аливаа асуудалд олон янзын байр сууринаас хандах, шүүн тунгаах улмаар бие даан өргөн хүрээнд уншиж судалдаг, тасралтгүй суралцах чадвартай хүн төлөвшүүлэхэд чухал үүрэгтэй.

Манай улсын хувьд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн

бодлогын I үе шатны хүрэх үр дүнд сурагчдын унших чадвартай холбоотой 2.1.21. Суралцагчдын сурлагын амжилтад нөлөөлөх хүчин зүйлийн судалгааг тогтмол хийж үр дүнд үндэслэн бодлого, төлөвлөлт хийж хэвшинэ. 7-14 насны хүүхдийн суурь чадвар (унших) 61.6 хувь байгааг 2025 онд 70 хувь, 2030 онд 75 хувь, 2050 онд 90 хувьд хүргэнэ гэж заасан бол Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 2.3.3. Ерөнхий боловсролын сургалтын чанарыг дэлхийн жишигт нийцүүлэх зорилгоор олон улсын PISA үнэлгээнд хамруулж, үндэсний чанарын үнэлгээний тогтолцоог бэхжүүлнэ гэсэн” зорилтуудыг дэвшүүлсэн байна. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 2.3.3. Ерөнхий боловсролын сургалтын чанарыг дэлхийн жишигт нийцүүлэх зорилгоор олон улсын PISA үнэлгээнд хамруулж, үндэсний чанарын үнэлгээний тогтолцоог бэхжүүлнэ гэсэн” зорилтуудыг дэвшүүлсэн байна. Ерөнхий боловсролын 12 жилийн 2-р ангийн суралцагчдын сурах хөдөлмөрийн ачааллыг тодорхойлох судалгааны тайлангаас харахад 7-8 настай сурагчдын 36.2 хувь нь 80 үгтэй танил бус эхийн агуулгыг эхний уншилтаар бүрэн ойлгодог болох нь тогтоогдсон байна. Давтан буюу 2 дахь уншилтын дараа нийт сурагчдын 20.6 хувь нь ойлгосон бол 10% нь эхийн утга санааг хангалттай ойлгоогүй, 18.3% нь эхийн утга санааг огт ойлгоогүй байсан байна. Иймд 7-8 настай сурагчдын 28.3% нь тухайн эхийг 3 ба түүнээс дээш удаа уншиж ойлгодог болохыг судалгаагаар тогтоожээ. Энэ судалгаагаар сурагчдын үг буруу уншиж байгаа шалтгааныг авч үзвэл тааж буруу унших 18.7 хувь, олон үетэй үг буруу унших 19.1 хувь, бусад буюу танил бус үг, я-гийн төрлийн үсэгтэй үгийг буруу унших нь 62.2 хувийг тус тус эзэлж байв.

Сурах бичгийн эхийн төрөл зүйлийн судалгаа

1-5 дугаар ангийн монгол хэлний сурах бичгийн нийт эхэд дараах хүснэгтийн дагуу шинжилгээний үр дүнг нэгтгэж харьцуулалт хийж үзлээ. 1 дүгээр ангид унших арга барилд анхлан суралцаж байгаа хүүхэддалд утга санаа багатай, энгийн хялбар 1-3 үетэй, аль болох 3 үеэс дээш хэтрэхгүй урттай үг уншихыг санал болгодог. Иймээс үлгэр гэхээс илүүтэй богино хялбар өгүүллэгүүд ихэвчлэн орсон байна. 2-4 дүгээр ангид үлгэр өгүүллэгийн харьцаа ойролцоо байна. Үлгэр 2-4-р ангид, өгүүллэг 5-р ангид, зүйр цэцэн үг, оньсого 1-2-р ангид түлхүү орж байна. Харин бэлгэ дэмбэрлийн үг нийт ангийн хэмжээнд 2 удаа орсон байна.

Хүснэгт 1. 1-5 дугаар ангийн монгол хэлний сурах бичгийн уран зохиолын эхийн ангилал

Эхийн ангилал	I анги	II анги	III анги	IV анги	V анги	Нийт
Уран зохиолын эх						
Үлгэр	3	12	15	20	6	56
Өгүүллэг	15	31	26	20	36	128
Шүлэг	11	26	9	13	4	63
Зүйр цэцэн үгс	10	9	6	5	2	19
Бэлгэ дэмбэрлийн үгс	1			1		2
Ергөнцийн гурав	5	6	10	5	5	21
Онсього	7	8	10	1	5	21
Нийт уран зохиолын эх	52	92	76	65	56	341

Уран зохиолын бус эхийн хувьд авч үзвэл 1-р ангид товч анкет, заавар, хаяг, шошго гэсэн нийт 2 эх, 2-р ангид талархал, мэндчилгээ, заавар, хаяг, шошго гэсэн нийт 7 эх, 3-р ангид заавар, хаяг, шошго, захидал төлөвлөгөө, номын тэмдэглэл гэсэн нийт 16 эх, 4-р ангид танилцуулга, захидал, номын тэмдэглэл, урилга, уриалга гэх мэт 18 эх, 5-р ангид захидал, сонины мэдээ, өдрийн тэмдэглэл зэрэг 10 хэрэглээний эх тус тус орсон байна.

Хүснэгт 2. 1-5 дугаар ангийн монгол хэлний сурах бичгийн хэрэглээний эхийн ангилал

Эхийн ангилал	I анги	II анги	III анги	IV анги	V анги	Нийт
Хэрэглээний эх						
Талархал		3				3
Мэндчилгээ		1				1
Товч анкет	1					1
Танилцуулга				3		3
Заавар хаяг шошго	1	3	8			12
Захидал			5	1	2	8
Төлөвлөгөө			2			2
Номын тэмдэглэл, танилцуулга			1	7	1	9
Сонины мэдээ				1	3	4
Урилга				3		3
Уриалга				3		3
Өдрийн тэмдэглэл					4	4
Нийт хэрэглээний эх	2	7	16	18	10	53
Анги бүрийн нийт эх	54	99	76	73	61	394


Мөн эхийн хэмжээнээс хамаарахгүйгээр нэг эхийн дундаж үгийг нийт эхийн хүрээнд авч үзэхэд I ангид нэг эхийн дундаж үг 26,4 үг, II анги 61 үг, III анги 139 үг, IV анги 160 үг, V анги 145 үг байна. Үүнээс харахад II ангиас III ангид дундаж үгийн тоо бусад ангитай харьцуулахад огцом нэмэгдэж байна.

Сурах бичгийн эхийн агуулга дахь мэдлэг, хандлагын судалгаа

2014 оны 4 дүгээр ангийн монгол хэлний сурах бичигт нийт 65 эх байгаагаас 17 хувь нь баримтын болон ухагдахууны мэдлэг (аянга цахилгаан цахихад өндөр модноос холдох, чөдрийн бүрэлдэхүүн элемент болох чөдрийн хаа, алга, хөх, чагт, суман гэж аль нь болох...) олгож байгаа бол хамгийн их буюу 82 хувь нь хандлага (шударга байх, сайн үйлд зориулж нэгэндээ аз жаргал бэлэглэж байгаа тухай, амьтныг хайрлаж усанд нь буцаан тавьж байгаа...) төлөвшүүлэхэд чиглэсэн байна. Харин ач холбогдолгүй буюу ёс суртахуунлаг бус үйлдлийг агуулсан эх 1 хувь (Намайг сансарт нисэхээр)-ийг эзэлж байна.

2020 оны монгол хэлний 2 дугаар ангийн сурах бичигт нийт 78 эх байгаагаас 52 хувь нь мэдлэг олгох (баримт, ухагдахуун, үйлийн мэдлэг), 40 хувь нь хандлага төлөвшүүлэхэд (үг сонсох, эдэлж хэрэглэж байгаа зүйлээ гамтай хэрэглэх, байгальтай зөв зохистой харилцах) чиглэсэн байна.

График 1. Эхийн агуулга дахь мэдлэг, хандлага




Үүнд: монгол уламжлалт тоглоом наадгайг тоглох арга, дэс дараалсан алхмуудыг тусгаж өгсөн нь тоглох үйлээр дамжуулан уламжлалт тоглоом наадгайг тоглож сурахад чиглэсэн хүүхдийн амьдрал, үйл ажиллагаанд ашиг тустай эх байна. Харин 5 хувь нь (Зоригтой туулай, Дайллага, Эрвээхэйн зам тохиолдсон явдал, Тэр миний найз) ёс суртахуунлаг бус үйлдлийг (хамтарч ажиллахдаа нэг нэгэндээ дэм тус болох бус саад болж байгаа, бусдын эд зүйлд зөвшөөрөлгүй хүрснийгээ өөрийн буруу алдаа гэж үзэхгүй байгаа) агуулсан байна. Сурах бичигт тусгагдсан эхийн 4 хувь нь (Амьтны хүрээлэнд, Барын бамбар, Цэцэгхэн хотын тагжгарууд) тухайн эх уншигчдад чухам ямар ач холбогдолтой байгаа нь тодорхой бус байна.

Сурах бичгийн эхийн агуулгын шинжилгээ

“Бага боловсролын монгол хэлний сургалтын цөм хөтөлбөр”-г анги болгонд унших болон бичих эхийн төрлүүдийг тусгаж мөн хэрэглэгдэхүүн сонгох зарчмыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: “Монгол хэлний хичээл нь аман зохиол, уран зохиолын болон найруулгын бусад төрлөөр бичигдсэн эхийг төсөөлөх, унших, хэлэлцэх, боловсруулах, бүтээлчээр зохион найруулж бичих замаар эх хэлээ хэрэглэх, бүтээлчээр сэтгэх арга барил хөгжүүлэх технологид суурилна” (БШУЯ, 2014)

Эхийн агуулга буюу утга санааны цогцоор илэрч буй утгын нэгжийн давхцалыг гаргаж, давхацсан утгын нэгжийг шаардлагаар тогтоох зорилгоор илэрхийлж буй агуулгаарнь ангилж үзэхэд дээр дурдсан эрх зүйн баримт бичигт дурдсан 8 утгын нэгжээс хүмүүнлэг энэрэнгүй байх, үндэсний түүх соёл, өв уламжлалаа эрхэмлэн дээдлэх, ёс суртахуунтай байх, сурах, ажиллах, амьдрах арга ухаантай байх, эрүүл аж төрөх, эх орноороо бахархах гэсэн 6 утгын нэгж нь адил байна. Харин авьяас чадвараа хөгжүүлэх, хүн төрөлхтний үнэт зүйлийг дээдлэн эрхэмлэх гэсэн утгын нэгж тусгагдаагүй байна.

Зураг 2. Сурах бичгийн эхийн агуулгын шинжилгээ



Сурах бичгийн эхийн агуулгад шинжилгээ хийхэд хүмүүнлэг, энэрэнгүй байхыг сургасан агуулга 6%, сурах, ажиллах, амьдрах арга, ухаанд сургасан эх 27%, эх орны сэдэвт эх 16%, өв уламжлалын агуулгатай эх 2%, түүхийн сэдэвт эх 5%, эрүүл аж төрөх агуулгатай эх 15% тус тус эзэлж байна.

Судалгааны үр дүн

Судалгаандаа дараах агуулгыг авч үзсэн. Үүнд:

1. Сурах бичгийн эхийн төрөл зүйлийн судалгаа

Энэ хэсэгт одоо ЕБС-д хэрэглэгдэж байгаа 1-5-р ангийн монгол хэлний сурах бичгийн нийт эхэд шинжилгээ хийсэн. 1-5-р ангид уран зохиолын 341 эх, уран зохиолын бус 394 эх байсан. Эхийн хэмжээнээс хамаарахгүйгээр нэг эхийн дундаж үгийг нийт эхийн хүрээнд авч үзэхэд I ангид нэг эхийн дундаж үг 26,4 үг, II анги 61 үг, III анги 139 үг, IV анги 160 үг, V анги 145 үг байна. Үүнээс харахад II ангиас III ангид дундаж үгийн тоо бусад ангитай харьцуулахад огцом нэмэгдэж байна.

2. Сурах бичгийн эхийн агуулга дахь мэдлэг хандлагын судалгаа

Шинжилгээ хийсэн монгол хэлний сурах бичгийн нийт эхийн 52 хувь нь мэдлэг олгох (баримт, ухагдахуун, үйлийн мэдлэг), 40 хувь нь хандлага төлөвшүүлэхэд (үг сонсох, эдэлж хэрэглэж байгаа зүйлээ гамтай хэрэглэх, байгальтай зөв зохистой харилцах) чиглэсэн байна.

3. Сурах бичгийн эхийн агуулгын шинжилгээ

Сурах бичгийн эхийн агуулгад шинжилгээ хийхэд хүмүүнлэг, энэрэнгүй байхыг сургасан агуулга 6%, сурах, ажиллах, амьдрах арга, ухаанд сургасан эх 27%, эх орны сэдэвт эх 16%, өв уламжлалын агуулгатай эх 2%, түүхийн сэдэвт эх 5%, эрүүл аж төрөх агуулгатай эх 15% тус тус эзэлж байна.

Дүгнэлт

Бид уг судалгааны хүрээнд бага боловсролын монгол хэлний 1-5-р ангийн сурах бичгийн эхэд шинжилгээ хийлээ. Ингээд уг судалгааны ажил нь дараах дүгнэлтийг агуулж байна. Үүнд:

1. Бага сургуулийн монгол хэлний сурах бичигт байгаа эхийн агуулга, арга зүй, хэл найруулгын шаардлагыг тусгайлан судлах шаардлагатай.
2. Сурах бичиг дэх эх нь тухайн хүүхдийн нас сэтгэхүй, хөгжилд нийцсэн байх, орчин үеийн шинэлэг мэдээ, мэдээллийг агуулсан байх хэрэгтэй. Тухайлбал: эх дэх өгүүлбэрийн тоо, өгүүлбэрийн хэв шинж, өгүүлбэр дэх үгийн тоо, үг дэх үеийн тоо гэх мэт.
3. Бага боловсролын эх хэлний сургалт нь эх дээр суурилдаг тул эхийн агуулгын залгамж холбоо, агуулгын давхцал, ач холбогдлыг сайтар харгалзах хэрэгтэй. Тухайлбал: зарим ангид ажил хөдөлмөрт сургасан агуулгатай их байхад, зарим ангид эрүүл аж төрөх, дадал хэвшил олгох эх байхгүй байх гэх мэт.

Талархал

Уг эрдэм шинжилгээний өгүүллийг бичихдээ Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн “Бага боловсролын монгол хэлний сургалтад ашиглах унших эхийн сан бүрдүүлэх” төслийн судалгааны зарим үр дүнгээс ашигласан болно. Иймд төслийн багийн гишүүдэд талархал илэрхийлье.

Ном зүй

- Алтанцэцэг, С., Мөнхцэцэг, Б. (2012) Орчин цагийн монгол хэлний эх судлал. Улаанбаатар. Базаррагчаа М., (1989) Монгол хэлний эхийн тухай. Улаанбаатар.
- Боловсрол, шинжлэх ухааны яам (2014) Бага боловсролын цөм хөтөлбөр. Улаанбаатар.
- Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн (2022) Бага боловсролын монгол хэлний сургалтад ашиглах унших эхийн сан бүрдүүлэх. Төслийн судалгааны тайлан. Улаанбаатар.
- Бэгз, Н., Санжаабадам, С., (2018) Хүүхэд, залуучуудын хөгжлийн онол, арга зүй. Улаанбаатар.
- Бямбацэрэн, Г., Болормаа, Г., Лхамноржмаа, Б., Хажидмаа, В., (2020) Монгол хэл II. Ерөнхий боловсролын сургуулийн 2 ангийн сурах бичиг. Улаанбаатар.
- Одсүрэн, П., Гэрэлсайхан, П., Даваасүрэн, Н., Дашдолгор, Ц. (2020) Монгол хэл III. Ерөнхий боловсролын сургуулийн 4 ангийн сурах бичиг. Улаанбаатар.
- Олзвой, Л., Оюунцэцэг, Б., Энхжаргал, М., Отгонцэцэг, Ш. (2020) Монгол хэл V. Ерөнхий боловсролын сургуулийн 5 ангийн сурах бичиг. Улаанбаатар.
- Оюунцэцэг, Ш, Хадаа Ө, Цогзолмаа Д, Энхтуяа Т. (2020) Монгол хэл I. Ерөнхий боловсролын сургуулийн 1 ангийн сурах бичиг. Улаанбаатар.
- Цэндсүрэн, Ө., Бигэрмаа, Р., Жаргалсайхан, П., Нямхүү, У. (2020) Монгол хэл III. Ерөнхий боловсролын сургуулийн 3 ангийн сурах бичиг. Улаанбаатар.
- Цог-Очир, А. Эрдэнэсан, Д. (2015) Монгол хэлний эхийн хэв маяг. Улаанбаатар.

**AN ANALYSIS OF MONGOLIAN LANGUAGE TEACHING IN
PRIMARY EDUCATION
(On the example of Mongolian language textbooks for primary education)**

^aEnkhjargal M.

^aPh.D, Lecturer, Teachers school, MNUE

Corresponding author: enkhjargal.m@msue.edu.mn 

Abstract

Educational researchers agree that reading, understanding what is read, and writing are the basic skills that affect the academic success of students, develop the basic skills of the mother tongue, increase vocabulary, and develop a creative minded Mongolian child. Many researchers have noted that the ability to read is not only to understand the content of the studied subjects, but also to choose what is needed from many sources of information, to approach and judge from different points of view, and then to read widely independently, many researchers have the ability to continuously learn.

The native language training is based on the “native language” of the language and aims to provide basic language skills such as reading the native language, speaking and listening, and writing what I understand. In this study, we present a study that analyses the content and genres of the textbooks used in Mongolian language teaching in elementary education.

Keywords

Textbooks, literary sources, applied sources, content of sources, types of sources